



**ХЭНТИЙ АЙМГИЙН БЭРХ ХОТЫН  
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 03 сарын 27 өдөр

Дугаар Б/04

Бэрх хот

Буцалтгүй тусламж  
үзүүлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах заалт, “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалт, “Төрийн албаны тухай” хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалт, Захирагчийн ажлын албаны 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.2.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Захирагчийн ажлын албаны Хог тээврийн жолооч Б.Бямбажавын эхнэр П.Өлзийбилэг нь Улаанбаатар хотын “Чих хамар хоолойн” эмнэлэгт яаралтай үзүүлэх болсон тул 300.000 (Гурван зуун мянган) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2.Буцалтгүй тусламжид шаардагдах 300.000 (Гурван зуун мянган) төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргаж олгохыг Захирагчийн ажлын албаны нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Э.МЯГМАРСҮРЭН

232 603 007